



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

“Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”, гэрчилгээний загвар батлах болон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.1.5, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 4.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтын загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 200,000,000.00 /хоёр зуун сая/ төгрөгөөр тогтоосугай.

3. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг 100,000 /нэг зуун мянга/ төгрөгөөр тогтоосугай.

4. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дад энэхүү журмын нөхцөл, шаардлагыг хангаж ажиллахыг үүрэг болгосугай.

5. Энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний газар /И.Цэрэн-Онолт/, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000028